Хураангуй. Амьдрах орчны доройтол, хуваагдал нь дэлхийн биологийн олон янз байдалд ноцтой аюул учруулсаар байгаа билээ. Монгол орны өргөн тархацтай амьтны нэг болох Халиун бугын амьдрах орчны холбогдох байдлыг уулсын мужлалаар үнэлэн популяцийн хамгаалалд санал зөвлөмж өгөх зорилгоор энэхүү ажлыг хийж гүйцэтгэв. Халиун бугын тохиолдоц болон уур амьстгал, газарзүйн болон хүний нөлөөллийн индекс зэрэг 7 хувьсагч үзүүлэлтэд тулгуурлан Максент (MaxEnt - Maximum Entropy Model) ашиглан тохиромжит амьдрах орчныг загварчилж, цөм амьдрах орчны холбогдох байдлыг гаргахдаа Linkage Mapper программ хангамж ашиглав. Хүний нөлөөллийн индекс болон өргөгрийн дагуу өөрчлөгдөн хувьсах уур амьстгалын үзүүлэлтүүд нь халиун бугын орон зайн байршилд чухал нөлөөтэй болохыг харуулж байна. Судалгаанд хамрагдсан бүс нутгийн хэмжээнд Халиун бугын 130 цөм амьдрах орчин (ЦАО), тэдгээрийг холбосон 386 боломжит холбоос нутаг (хамгийн бага өртөг бүхий зам) байна. Хэнтий болон Хөвсгэлийн уулсын мужлал дахь Халиун бугын холбоос нутгийн урт харьцангуй богино байгаа нь тус уулсын мужид амьдрах орчны тохиромжит байдал бусад нутгаас харьцангуй илүү байгааг илтгэн харуулна. Харин Алтай болон Хангайн уулархаг нутагт тохиромжит амьдрах орчны хэмжээ бага байхаас гадна цөм амьдрах орчин илүү тасархайтсан, илүү урт холбоос нутагтай болох нь загварчлалын үр дүнд тогтоогдов. Энэхүү судалгааны үр дүнд халиун бугын холбоос нутагтай огтлолцож буй шугаман дэд бүтэц бүхий нутгийг тодорхойлон гаргав.

Түлхүүр үгс: цөм амьдрах орчин, хамгийн бага өртөг бүхий зам, ач холбогдлын эрэмбэ, халиун буга

Хүлээн авсан 2022.10.09; хянан тохиолдуулсан 2022.12.25; зөвшөөрсөн 2022.12.27

© 2022 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз.](#)

Оршил

Халиун буга буюу *Cervus canadensis* (өмнөх нэршил нь *Cervus elaphus* гэх) нь манай орны Хөвсгөл, Хангай, Хэнтий болон Алтайн уулархаг бүс нутагт өргөн тархана [1], [2]. Монгол орны Халиун бугын тоо толгой 1980-аад оны дунд үед тоо толгой 130,000 [3] хүрч байсан бол ижил арга зүйгээр хийгдсэн судалгааны үр дүнгээр 2004 онд 8,000 – 10,000 болж 77%-иар буурчээ [4]. Дорно дахинын уламжлалт анагаах ухаанд эд эрхтнийг ашиглах зорилгоор хууль бусаар агнах, уул уурхай, дэд бүтцийн хөгжил,

түүнийг дагасан бүтээн байгуулалт нь популяцид нөлөөлөх, амьдрах орчны хуваагдалд хүргэх үндсэн хүчин зүйл юм [5]. Халиун буга нь Дэлхийн байгаль хамгаалах холбооны (ДБХХ) зүйлийн ховордлыг үнэлэх ангиллаар олон улсад анхааралд өртөхөөргүй гэж үнэлэгдсэн, Монгол улсын Амьтны тухай хуульд “ховор” ангилалд багтаж тусгай зориулалтаар олзворлодог амьтдын нэг юм [5]. Монгол орны Халиун бугын тархац нутгийн 33% нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.

Аливаа ховор болон ховордсон зүйлийн газарзүйн тархалт нь тухайн амьтны амьдрах орчны хоорондох

шилжилт хөдөлгөөний холбоос нутгийг тодорхойлох үндэс суурь болохоос [6] гадна ландшафтын олон түвшинд хамгааллын арга хэмжээг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм [7].

Бид Халиун бугын тохиолдцын мэдээлэлд үндэслэн тохиромжит амьдрах орчин болон цахилгаан хэлхээний онолд суурилсан холбоос нутгийн загварчлалыг нэгтгэн (нэгдүгээрт) Халиун бугын орон зайн байршил нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох; хоёрдугаарт) цөм амьдрах орчин, тэдгээрийн хоорондох холбоос нутгийг үнэлэхийг зорив.

Судалгаанд хамрагдсан нутаг


Судалгааны талбайн нийт хэмжээ нь 789,291 км² бөгөөд Алтай-Саян, Хангай-Хэнтийн гэх үндсэн 2

уулархаг бүс нутгийг хамарна. Алтай-Саяны бүс нутаг нь Алтайн болон Хөвсгөлийн уулсын; харин Хангай-Хэнтийн уулархаг их муж нь Хангайн болон Хэнтийн нуруу гэх дэд мужуудад хуваагдана (**1-р зураг**). Манай орны баруун болон баруун өмнөд хэсгээр сунан тогтсон Алтайн нуруу нь хамгийн өндөр, хамгийн урт үргэлжилсэн нуруунд тооцогдоно [8]. Судалгаанд хамрагдсан бүс нутгийг Коппенийн уур амьсгалын ангиллаар дулаан зунтай, хагас чийглэг; хүйтэн зунтай, чийглэг; маш хүйтэн зунтай, чийглэг гэх үндсэн 3 бүсэд хуваан үзэж болно [9], [10].


Судалгаанд хамрагдсан бүс нутаг нь 1,765,510 хүн амтай (үүнээс баруун бүс: 416,849; хангайн бүс: 605,315; төвийн бүс: 517,112; зүүн бүс: 226,234). Бүс нутгийн хэмжээнд малчдын тоо 2012 оноос хойш

1-р хүснэгт. Амьдрах орчны загварчлалд ашигласан хүрээлэн буй орчны хувьсагч

Нэр	Нарийвчлал	Эх сурвалж
Өндрийн тоон загвар (DEM)	15 арк-секундийн нарийвчлалтай SRTM-ийн орон зайн мэдээтэй тохирох 425м-ийн нарийвчлалтай, UTM 48N тусгагтай.	NASA/JPL (2005); Lehner <i>et al.</i> (2008), нарын бүтээлийг Heinar <i>et al.</i> [12]
Налуу	DEM, ESRI ArcGIS Slope-ээс үүсгэсэн	The Nature Conservancy Mongolia Program, Heinar <i>et al.</i> [12]
Гадаргын атираат хэлбэршил	DEM-ээс үүсгэсэн	Sappington <i>et al.</i> (2007) нарын бүтээлийг Heinar <i>et al.</i> [12]
Хүний нөлөөллийн индекс	15 арк-секундийн нарийвчлалтай SRTM-ийн орон зайн мэдээтэй тохирох 425м-ийн нарийвчлалтай, UTM 48N тусгагтай.	The Nature Conservancy Mongolia Program, Heinar <i>et al.</i> [12]
Био 19 уур амьсгалын үзүүлэлт	15 арк-секундийн нарийвчлалтай SRTM-ийн орон зайн мэдээтэй тохирох 425м-ийн нарийвчлалтай, UTM 48N тусгагтай.	paleoclim.org (Одоогийн уур амьсгалын Био 19 хувьсагч (Bioclimatic variables) нь 1970-2013 оны хоорондох дундаж утгаар илэрхийлэгдэнэ.)



1-р зураг. Судалгаанд хамрагдсан нутаг



2-р зураг. Судалгаанд хамрагдсан бус нутгийн малчин өрх, малын тоо толгой

өссөн байх ба 2021 онд 66,9 сая толгой мал (хонь 50.8%, ямаа 31.5%, адтуу 8.9%, үхэр 8.8%, тэмээ 0.2%) тоологджээ (**2-р зураг**; Үндэсний статистикийн газар, 2022).

Арга зүй

Халиун бугын тохиолдоц, боловсруулалтанд ашигласан хүрээлэн буй орчны хувьсагчид

Халиун бугын боломжит амьдрах орчны загварчлах зорилгоор “Биосан” мэдээллийн сан, үндэсний болон бус нутгийн хэмжээнд хийгдсэн тооллогын үр дүнгээс шүүлт хийн 2015-2021 онд хамаарах 2,536 мэдээллийг нэгтгэв. Цэгэн мэдээллийн давхцалыг багасгах, мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор 83 давхардсан цэгэн мэдээллийг боловсруулалтаас хасаж, нийт 2,453 Халиун бугын тохиолдцын мэдээг ArcGIS 10.6 хувилбарын тусламжтайгаар MaxEnt программд оруулан тохиромжит амьдрах орчны загварчлахад ашигласан [11].

Халиун бугын тархалтыг тодорхойлох хүрээлэн буй орчны хүчин зүйлийг сонгохын тулд 1950–2013 оны хооронд хамаарах 19 хувьсагч үзүүлэлт бүхий 1 км² нарийвчлалтай уур амьсгалын мэдээ буюу Bio-19 давхаргыг (<http://www.paleoclim.org/>) ашигласнаас гадна өндөршил, налуу, газрын гадаргын атираажилт болон хүний нөлөөллийн индекс [12] гэсэн дөрвөн үзүүлэлтийг нэмэлт шүүлтүүр болгосон (**1-р хүснэгт**). Эдгээр давхаргудыг ArcGIS 10.6 программын SDM хэрэглүүрийг ашиглан ижил хэмжээ болон нарийвчлалтай болгон хувиргав.


Тохиромжит амьдрах орчны загварчлал

Тохиромжит амьдрах орчны загварчлалыг MaxEnt программ [13] ашиглан гүйцэтгэв. Хүчин зүйлүүдийн хоорондох корреляци хамаарлыг Пиерсоны шалгуураар үнэлэн 0.75-аас их хамааралтай хувьсагч утгуудыг хассан [14]. Эцсийн тооцоололд өдрийн дундаж температур (Bio2), изотермал (BIO2/BIO7) ($\times 100$) болон хур тунадас улирлын хамаарал (Bio15) гэсэн 3 хувьсагчийг ашиглов. Загварчлалын оновчтой хувилбарыг R программын ENMeval өргөтгөл ашиглан тодорхойлсон бөгөөд нийт мэдээллийн 75%-ийг model training, 25%-ийг загварыг шалгах [15] тохиргоог хийн Максент загварыг үншуулав. Судалгаанд ашигласан цэгэн мэдээллийн тоо 50-иас их байгаа учир харгалзах загварыг 10 удаагийн давталттайгаар үншуулан стандарт хазайлт бүхий дундаж утгыг нэгтгэсэн. Максент программ дээр үншуулсан загваруудыг 0-ээс 1 хүртэл утга авах муурийг (AUC) ашиглан үнэлж, амьдрах орчны загварт аль хүчин зүйл илүү нөлөөлж байгааг Жекнайф тестээр (Jackknife test) тодруулав.

Амьдрах орчны растер зургийг (0-1 хүртэлх ангилал бүхий) ArcGIS 10.6 программ ашиглан боловсруулалт хийж тохиромжтой бус амьдрах орчин (0–0.2 буюу I); бага зэрэг тохиромжтой (0.2–0.5 буюу II); дунд (0.5–0.7 буюу III); сайн (0.7–0.8 буюу IV); маш сайн (0.8–1.0 буюу V) гэсэн 5 ангилалд хуваан үзэв (**3-р зураг**).

Холбоос нутгийг зурагласан байдал

Цөм амьдрах орчны хоорондох холбоос нутгийг (least-cost path) тодорхойлоходоо цахилгаан хэлхээний онолтой нэгтгэсэн арга зүйн дагуу Linkage Mapper



3-р зураг. Монгол орны халиун бугын тохиромжит амьдрах орчин (уулсын мужлалаар)

[16] программ ашиглан зураглав. Энэхүү программ нь орон зайн өгөгдөл үндэслэн амьдрах орчин хоорондын холбогдох байдлын зураглалыг үүсгэж, зардлын жигнэсэн зай (cost weighted distance) ба боломжит холбоос нутгийг тооцоолж, тэдгээрийг нэгтгэн зурагладаг.

Холбоос нутгийн үнэлгээ

Ач холбогдлын үнэлгээ: Амьдрах орны холбогдох байдалд цөм амьдрах орчин болон холбоос нутаг хэр зэрэг чухал болохыг Circuitscape программд суурилсан Centrality mapper хэрэглүүр ашиглан тодорхойлов [16], [17].

Холбоос нутгийн чанарын үнэлгээ: Холбоос нутаг тус бүрийн чанарыг цөм амьдрах орчин хоорондын Эвклидийн зайд (CWD: EucD) хуваасан зардлын жигнэсэн зай; зардлын жигнэсэн зайл боломжит

холбоос нутгийн урттай харьцуулсан харьцаа (CWD: LCP) гэсэн хоёр хэмжигдэхүүнээр тооцсон [18, 19]. Эхний хэмжүүр нь цөм амьдрах орчин хоорондоо ойрхон байгаагаас үл хамааран тэдгээрийн хооронд шилжихэд хэдий хэр хүндрэлтэй болохыг илтгэх бол хоёрдох хэмжүүр нь цөм амьдрах орчны хоорондоо зам дагуу эсвэл дунд таарч буй дундаж эсэргүүцлийг тооцдог.

Саад тогторын үнэлгээ

Barrier Mapper нь коридорын байршил эсвэл чанарт нөлөөлж буй “саад тогтор”-ыг үнэлдэг. “Саад тогтор буюу эсэргүүцэл” гэсэн томьёололд зэрлэг амьтан дамжин өнгөрөхөд хэцүү, хүндрэлтэй байх ландшафтын хэсгийг багтаан ойлгож болно [20]. Үндсэндээ тэд нөхөн сэргээх, эсвэл саад тогторыг бууруулах шаардлагатай газруудыг тодорхойлно.

Үр дүн

Максентзагварчлалаар 181,419 км² талбайг хамарсан 130 цөм амьдрах орчин (ЦАО) тодорхойлогдсон нь судалгааны талбайн 22.9%-тай тэнцэнэ. Халиун бугын тархац байршил бүхий амьдрах орчны талбайн дундаж утга нь 1,664 км² ($SD = 6,614$) байв. Хэнтийн нуруу (50,225 км²) нь Халиун бугын хамгийн том талбайтай цөм амьдрах орчин байх бол Хангайн нуруу (34,256 км²; **3-р зураг**) удаална.

Халиун бугын тархац нутагт үзүүлэх ач холбогдол, талбайн хэмжээгээрээ Хангай-Хэнтийн (118,595.0 км² буюу 76.6%) уулархаг нутаг тэргүүлэх бол Алтай-Саяны (11,700.6 км² буюу 14.5%) бус удаална. Хангайн, Хэнтийн гол нурууд болон Хөвсгөлийн уулсын баруун хэсэг нь амьдрах орчны холбогдох байдал чухал ач холбогдолтой болохыг харуулна (**4-р зураг, 2-р хүснэгт**).

Шилжилт хөдөлгөөний холбоос нутгийн ач

холбогдлын эрэмбээр Монгол орны төвийн хэсэг чухал ач холбогдолтойд тооцогдоно. Холбоос нутгийн үнэлгээ нь судалгаанд хамрагдсан 4 уулсын мужлалаар харилцан адилгүй байв (**3-р хүснэгт**). Амьдрах орчны холбогдох байдал, нэгдмэл чанарыг илтгэх холбоос нутгийн үзүүлэлтээс харвал Хөвсгөлийн уулсад (CWD: to EucD = 89.3 ± 33.5) амьдрах орчны тохиромжит байдал өндөр, хил залган орших Хангайн нуруунд ($Mean \pm SD = 180.4 \pm 28.8$) бага байна. Харин холбоос нутгийн хоорондох саад тогторыг илэрхийлэх тоон үзүүлэлт Хөвсгөлийн уулсад (CWD: to LCP; $Mean \pm SD = 66.1 \pm 18.6$) хамгийн бага, Хэнтийн нуруунд хамгийн их байна (**5-р зураг, 3-р хүснэгт**).

Халиун бугын тохиолдоц, амьдрах орчны холбогдох байдалд нөлөөлж буй хүчин зүйлс

Нэг хүчин зүйлт ANOVA дүн шинжилгээгээр судалгаанд хамрагдсан нийт нутагт Халиун бугын

2-р хүснэгт. Халиун бугын цөм амьдрах орчны (ЦАО) ач холбогдлын үнэлгээ.


Эрэмбэ	Ач холбогдлын утга	Тоо	Дундаж ± SD	95% CI	ЦАО-ны талбай/ хувь
Хангай-Хэнтийн уулархаг муж					
1	478 – 842	3	526 ± 25.3	508.8-555.1	118,595 / 76.6%
2	320 – 477	1	362.8 ± 0.0	–	11,219 / 7.2%
3	215 – 319	3	273.6 ± 27.1	255.9-304.8	5,198 / 3.4%
4	138 – 214	14	162.1 ± 20.6	141.2-213.9	11,614 / 7.5%
5	64 – 137	26	96.1 ± 19.7	64.3-133.2	8,147 / 5.3%
Алтай-Саяны уулархаг муж					
1	478 – 842	5	631.5 ± 169.0	495.6 – 842.2	11,701 / 43.9%
2	320 – 477	15	390.1 ± 52.3	328.9 – 477.3	6,865 / 25.8%
3	215 – 319	14	265.0 ± 29.5	222.2 – 318.6	2,642 / 9.9%
4	138 – 214	23	184.6 ± 18.1	151.9 – 212.5	4,762 / 17.9%
5	64 – 137	26	96.1 ± 19.7	64.3 – 133.2	676 / 2.5%
Нийт					181,419

3-р хүснэгт. Холбоос нутгийн ач холбогдлын үзүүлэлт

Бүс нутаг	Холбоос нутгийн тоо	Боломжит холбоос нутгийн урт (LCP) / км	Эвклидиин зай (EucD) / км	Зардлын жигнэсэн зай (CWD) / км	CWD: EucD	CWD:LCP	Ач холбогдол
Хөвсгөл	73	52 ± 63	38.3 ± 47.0	3,390.5 ± 4,052.6	89.3 ± 33.5	66.1 ± 18.6	84.7 ± 68.7
Алтай	180	106.3 ± 147.5	71.4 ± 90.1	7,227.9 ± 9,928.1	92.6 ± 35.7	67.0 ± 26.2	87.3 ± 58.3
Хангай	107	71.1 ± 124.7	50.1 ± 79.3	5,583.1 ± 6,990.7	132.1 ± 54.2	101.3 ± 50.9	65.5 ± 52.8
Хэнтий	26	26.8 ± 25.0	24.0 ± 23.0	4,340.0 ± 4,218.3	180.4 ± 28.8	158.6 ± 31.9	45.5 ± 34.5

4-р хүснэгт. Максент загварчлалаар тодорхойлогдсон амьдрах орчны градиентын дагуух халиун бугын тархац, боломжит холбоос нутгийн урт

Үзүүлэлт/ангилал	Алтай	Хангай	Хөвсгөл	Хэнтий
Хүний нөлөөллийн индекс	4.5 ± 1.8	3.3 ± 1.1	4.1 ± 1.9	3.9 ± 1.5
Өндөршил	$2,353 \pm 200$	$1,705 \pm 292$	$1,903 \pm 367$	$1,217 \pm 300$
Налуу	6.9 ± 3.4	5.6 ± 2.5	7.3 ± 5.7	4.1 ± 2.9
Талбайн хэмжээ, км²	267,175	328,812	69,855	110,984
Тохиромжтой бус (I)	168,067	79,145	4,854	31,501
Бага зэрэг тохиромжтой (II)	54,871	104,772	18,420	30,112
Дунд (III)	26,812	70,765	24,985	25,290
Сайн (IV)	9,468	38,389	13,259	12,955
Маш сайн (V)	7,957	35,738	8,335	11,125
Бага өртөг бүхий холбоос нутгийн урт, км	10,310	9,404	6,178	697.8
Тохиромжтой бус (I)	869	442.1	42.8	207.0
Бага зэрэг тохиромжтой (II)	1,607	1,562	417.2	385.8
Дунд (III)	2,725	1,789	2,047	94.9
Сайн (IV)	2,121	1,662	1,596	8.4
Маш сайн (V)	2,988	3,947	2,075	1.7



4-р зураг. Халиун бугын цөм амьдрах орчны ач холбогдолын үнэлгээ

тохиолдоц ($F_{(3, 2453)} = 5.76, P = 0.0002$), налуу, хүний нөлөөллийн индекс харилцан адилгүй байна. Хангайн нуруунд Халиун буга тархан байрших боломжит талбай болон боломжит холбоос нутгийн урт бусад нутгаас илүү их байна. Тархац нутгийн дийлэнх хэсэг 491,744 км² буюу 63.3% нь тохиромжит амьдрах орчны I болон II ангилалд, үлдсэн 285,083 км² буюу 36.7% нь III-V ангилалд хамрагдана. Халиун бугын амьдрах орчны сайн, маш сайн гэсэн ангилалд тархац нутгийн ердөө 16.6%, харин боломжит холбоос нутгийн дийлэнх хэсэг нь буюу 54.2% нь хамрагдаж байна (**4-р хүснэгт**).


Хамгийн сайн буюу тавдугаар ангилалд хамрагдсан амьдрах орчин дахь холбоос нутаг нь Хангайн нуруунд (3,947 км² буюу 43.8%) хамгийн өндөр, Хэнтий нуруунд (ердөө 1.7 км² буюу 0.02%) хамгийн бага байна. Тохиромжит амьдрах орчин нь өндөршил нэмэгдэхийн хирээр буурах хандлагатай байна. Дундаж өндөршил бүхий нутагт Халиун

бугын тохиромжит амьдрах орчин, тэдгээрийн талбайн хэмжээ нэмэгдэнэ гэж дүгнэж болно (**4-р хүснэгт**).


Хэлэлцүүлэг

Амьдрах орчны загварчлалыг гаргахад нийт 2,453 цэгийг ашигласан нь статистик шаардлагад нийцэхүйц хангалттай [21], [22] бөгөөд цаг хугацааны хувьд ч гэсэн хүрээлэн буй орчны хувьсагч утгуудтай нийцэж байна. Тиан нар [23] өндөршлийн дагуух температур, гэрэлтүүлэг болон налуугийн ялгарал нь зэрлэг амьтдын орон зайн жигд бус тархалтыг үүсгэж болзошгүй гэж дүгнэжээ. Монгол орны Халиун бугын орон зайн тархалт, амьдрах орчны холбогдох байдалд цаг уурын болон хүний хүчин зүйл чухал нөлөөтэй болохыг бидний үр дүн илтгэнэ.

Vollstädt нарын [24] цаг уурын хүчин зүйлүүд нь



5-р зураг. Халиун бугын цөм амьдрах орчныг холбосон холбоос нутаг (дээд) болон боломжит холбоос нутгийн ач холбогдлын эрэмбэлэлт (доод).



6-р зураг. Barrier Mapper дүн шинжилгээгээр тодорхойлсон холбоос нутгийн саад тогторын үнэлгээ

ургамлын бүлгэмдлээр дамжуулан зэрлэг ан амьтдын популяцид шууд бус нөлөө үзүүлдэг болохыг тодорхойлсон судалгааны үр дүн бий. Халиун буга нь амьдрах орчны олон хэлбэрт амьдрах учир тэдгээрийн тархалтад хур тунадас, температурын горим чухал нөлөөтэй байж болзошгүй. Өөрөөр хэлбэл, ургамлын тодорхой бүлгэмдэл бүрэлдэн бий болоход цаг уурын тодорхой нөхцөл шаардаг тул Халиун бугын орон зайн тархалтад шууд нөлөөлж болох юм.

Амьдрах орчны хуваагдал нь хүний үйл ажиллагаанаас үүдсэн хоёр дахь том нөлөөлөл [25], [26] бөгөөд сүүлийн жилүүдэд хүний үйл ажиллагаанаас улбаалсан газар ашиглалт улам бүр нэмэгдэж байгаа нь амьдрах орчны үр ашигтай талбай, амьдрах орчны доторх болон тэдгээрийн хоорондох холбоос нутгийг бууруулах гол шалтгаан юм [27].

Судалгааны үр дүн нь хүний нөлөөлөл багатай газарт Халиун бугын тохиолдоц, цөм амьдрах орчны талбай болон холбоос нутгийн хэмжээ нэмэгдсэн байгааг илтгэн харуулж байна. Хамгааллын үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд эхлээд Халиун бугын амьдрах орчны загварчлалд үндэслэн хамгийн тохиромжтой амьдрах орчныг сонгон авах хэрэгтэй. Ландшафтын түвшинд амьдрах орчны холбогдох байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг эхний ээлжинд тодорхойлох нь тухайн зүйлийн хамгааллын менежмент амжилттай хэрэгжихэд

чухал нөлөөтэй [28].

Халиун бугын амьдрах орчны холбогдох байдалд нөлөөлж буй саад тогторын дийлэнх нь Монгол орны баруун хойд хэсэгт тодорхойлогдсон (**6-р зураг**). Халиун бугын амьдрах орчны холбогдох байдалд аймгийн төв, уурхай, хилийн боомтыг холбосон томоохон хатуу хучилттай болон сайжруулсан зам ихээхэн нөлөөтэй. Тухайлбал, Улиастай-Улаангом (8); Алтай-Өлгий (6), Эрдэнэсант-Арвайхээр (12), Норовлин-Баян-Уул (15), Цагаан нуур-Улаан байшинт (1, 2); Хатгал – Ханх (10) болон Баянтэс-Арц суурь (9) хилийн боомтыг чиглэсэн хатуухучилттай болон сайжруулсан шороон замууд хамгийн их нөлөөтэйд тооцогдоно (**6-р зураг**). Бидний судалгаа нь халиун бугын амьдрах орчны холбоос нутгийг тодорхойлохиin зэрэгцээ ачаалал ихтэй төв замуудтай хэрхэн огтолцож буйг тодруулах явдал байсан бөгөөд зэрлэг ан амьтдын шилжилт хөдөлгөөн, орон зайн тархалтыг хангах зорилгоор нөлөөл нихтэй шугаман дэд бүтцийн зарим хэсэгт гарц гарам байгуулах шаардлагатайг харуулж байна.

Дүгнэлт

Амьдрах орчны MaxEnt загвар болон холбоос нутгийн загварчлалыг хослуулан Монгол орны халиун бугын хувьд 130 цөм амьдрах орчин, 386 холбоос нутгийг тодорхойлов. Судалгаанд халиун

бугын 2,453 тохиолдоц болон уур амьсгал, газарзүйн болон хүний хүчин зүйл зэрэг төрлийн хүчин зүйлд бүлэглэсэн 7 хувьсагч үзүүлэлтийг ашигласан. Эдгээр хүчин зүйлүүдээс халиун бугын амьдрах орчны холбогдох байдал болон холбоос нутгийн уртад хүний хүчин зүйл хамгийн их нөлөөтэй байна. Тохиромжтой амьдрах орчны талбайн хэмжээ өндөршил нэмэгдэхийн хэрээр буурах бол дундаж өндөрлөг уулсад нэмэгдэх хандлагатай байна. Халиун бугын цөм амьдрах орчин болон холбоос нутгууд нь хатуу хучилттай авто замтай огтолцож байна. Тиймээс амьдрах орчны нэгдмэл байдлыг тогтвортой хадгалах үүднээс нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай.

Талархал

Тусгай хамгаалалттай газар нутгийн биологийн төрөл зүйлийн мониторинг судалгааны Биосан мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг санаачлан эхлүүлж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласан Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын хамт олонд гүн талархал илэрхийлье. Монгол орны халиун бугын тархац, амьдрах орчинтой холбоотой суурь мэдээллийг бүрдүүлэх мониторинг судалгаанд оролцож буй нийт тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нар, мэргэжилтэн нарт талархаж байна.

Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлсэн “Халиун бугын тархац, нөөц, зохистой ашиглах хэмжээг тогтоох, хамгааллын статусыг тодорхойлох (ШУУЗ 2019/09)” захиалгат ажлын хүрээнд Монгол орны халиун бугын тархац, байшил, тоо толгойтой холбогдох мэдээллийг шинэчлэн боловсруулах ажлыг удирдан гүйцэтгэсэн МУИС-ийн Биологийн тэнхимийн эрдэмтэн, судлаач нарт талархал илэрхийлж байна.

Ашигласан бүтээл

- [1] А. Г. Банников, *Млекопитающие Монгольской Народной Республики* (Труды Монгольской комиссии,

вып. 53). Москва: Академия наук СССР, 1954, p. 669.

- [2] С. Дуламцэрэн, *Монгол орны хөхтөн амьтад: Хангай, Хэнтий нурууны туруутан амьтдын экологи, агуурын ач холбогдол*. 1989, p. 160.
- [3] Н. Батсайхан, С. Шар, Д. Лхагвасүрэн, S. R. B. King, and P. Самьяа, Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага, 3 ed. 2022.
- [4] Ж. Р. Вингард *et al.*, *Зэлүүд тал: Зэрлэг амьтны хууль бус худалдааны хямрал*. Лондон: Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг, 2006.
- [5] E. L. Clark нар, Монгол орны хөхтөн амьтдын улаан данс. Адмон, 2006. [Online]. Available: <https://archive.nationalredlist.org/files/2012/08/Mongolia-Red-List-of-Mammals-2006-Mongolian-.pdf>.
- [6] J. A. Wiens, N. C. Stenseth, B. V. Horne, and R. A. Ims, "Ecological Mechanisms and Landscape Ecology," *Oikos*, vol. 66, no. 3, p. 369, 1993, <https://doi.org/10.2307/3544931>.
- [7] K. R. Crooks and M. A. Sanjayan, "Connectivity Conservation: Maintaining Connections for Nature," pp. 1-20, 2006.
- [8] A. M. Savada and R. L. Worden, *Mongolia: a country study*, 2 ed. Washington, D.C: Federal Research Division, 1991, p. 320.
- [9] H. E. Beck, N. E. Zimmermann, T. R. McVicar, N. Ver-gopolan, A. Berg, and E. F. Wood, "Present and future Köppen-Geiger climate classification maps at 1-km resolution," *Sci. Data*, vol. 5, no. 180214, 2018, <https://doi.org/10.1038/sdata.2018.214>.
- [10] M. Kottek, J. Grieser, C. Beck, B. Rudolf, and F. Rubel, "World Map of the Köppen-Geiger climate classification updated," *Meteorologische Zeitschrift*, vol. 15, no. 3, pp. 259-263, 2006, <https://doi.org/10.1127/0941-2948/2006/0130>
- [11] J. Elith, S. J. Phillips, T. Hastie, M. Dudik, Y. E. Chee, and C. J. Yates, "A statistical explanation of MaxEnt for ecologists," *Diversity and Distributions*, vol. 17, pp. 43-57, 2011.
- [12] M. Heiner *et al.*, "Modeling habitat connectivity of a nomadic migrant facing rapid infrastructure development: Khulan habitat connectivity in the Southeast Gobi Region, Mongolia," *The Nature Conservancy*, Ulaanbaatar, 2016.
- [13] S. J. Phillips, R. P. Anderson, and R. E. Schapire, "Maximum entropy modeling of species geographic distributions," *Ecological Modelling*, vol. 190, no. 3-4, pp. 231-259, 2006, <https://doi.org/10.1016/j.ecolmodel.2005.03.026>.
- [14] M. H. Graham, "Confronting multicollinearity in ecological multiple regression," *Ecology*, vol. 84, no. 11,

- pp. 2809-2815, 2003, <https://doi.org/10.1890/02-3114>.
- [15] S. J. Phillips, "Transferability, sample selection bias and background data in presence-only modelling: a response to Peterson *et al.* (2007)," *Ecography*, vol. 31, no. 2, pp. 272-278, 2008, <https://doi.org/10.1111/j.0906-7590.2008.5378.x>.
- [16] B. H. McRae and D. M. Kavanagh, "Linkage mapper user guide," 2011. [Online]. Available: <http://www.circuitscape.org>.
- [17] C. Carroll, B. McRae, and A. Brooks, "Use of Linkage Mapping and Centrality Analysis Across Habitat Gradients to Conserve Connectivity of Gray Wolf Populations in Western North America," *Conservation Biology*, vol. 26, pp. 78-87, 2 2012, <https://doi.org/10.1111/j.1523-1739.2011.01753.x>.
- [18] T. Dutta, S. Sharma, B. McRae, P. S. Roy, and R. DeFries, "Connecting the dots: mapping habitat connectivity for tigers in central India," *Regional Environmental Change*, vol. 16, no. S1, pp. 53-67, 2016, <https://doi.org/10.1007/s10113-015-0877-z>.
- [19] C. Qiangqiang *et al.*, "Identification of potential ecological corridors for Marco Polo sheep in Taxkorgan Wildlife Nature Reserve, Xinjiang, China," *Biodiversity Science*, vol. 27, no. 2, pp. 186-199, 2019, <https://doi.org/10.17520/biods.2018264>.
- [20] B. H. McRae. *Barrier Mapper Connectivity Analysis Software*. [Online] Available: Available from <https://linkagemapper.org>
- [21] M. Heiner *et al.*, "Identifying Conservation Priorities in the Face of Future Development: Applying Development by Design in the Mongolian Gobi," *The Nature Conservancy*, Ulaanbaatar, 2017.
- [22] K. P. Burnham and D. R. Anderson, "Model Selection and Inference," 1998, <https://doi.org/10.1007/978-1-4757-2917-7>
- [23] C. Tian *et al.*, "Impacts of livestock grazing, topography and vegetation on distribution of wildlife in Wanglang National Nature Reserve, China," *Global Ecology and Conservation*, vol. 20, p. e00726, 2019, <https://doi.org/10.1016/j.gecco.2019.e00726>.
- [24] M. G. R. Vollstadt *et al.*, "Direct and indirect effects of climate, human disturbance and plant traits on avian functional diversity," *Global Ecology and Biogeography* vol. 26, no. 8, pp. 1-10, 2017, <https://doi.org/10.1111/geb.12606>.
- [25] R. M. Ewers and R. K. Didham, "Confounding factors in the detection of species responses to habitat fragmentation," *Biological Reviews*, vol. 81, no. 1, pp. 17-42, 2005, <https://doi.org/10.1017/S1464793105006949>.
- [26] A. Henrik., "Effects of Habitat Fragmentation on Birds and Mammals in Landscapes with Different Proportions of Suitable Habitat: A Review," *Oikos*, vol. 71, no. 3, p. 355, 12 1994, <https://doi.org/10.2307/3545823>.
- [27] M. Panahandeh, A. R. Yavari, E. Salehi, and B. Malekmohammadi, "Analyses of habitat changes of Caspian Red Deer (*Cervus elaphus maral* Gray, 1850) based on temporal changes of effective area and functional connectivity – A case study of Lisar protrected area," *Applied Ecology and Environmental Research*, vol. 14, no. 4, pp. 71-83, 2016, https://doi.org/10.15666/aeer/1404_071083.
- [28] Y. van der Hoek, B. Zuckerberg, and L. L. Manne, "Application of habitat thresholds in conservation: Considerations, limitations, and future directions," *Global Ecology and Conservation*, vol. 3, pp. 736-743, 2015, <https://doi.org/10.1016/j.gecco.2015.03.010>.